



БАТЛАВ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

БАТЛАВ

РЭД ЛАЙН ХХК-ИЙН ЗАХИРАЛ

С. БОЛДБААТАР

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны 01 дугаар сарын 24 -ны өдөр

№ 16

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Сөүлийн гудамж - 41 хаягт байрлах, регистрийн 5120829 дугаартай Авлигатай тэмцэх газар /цаашид "Захиалагч" гэх/-ыг төлөөлж Санхүү, аж ахуйн албаны дарга, ахлах комиссар Ш.Азбаяр:

Нөгөө талаас Сүхбаатар дүүрэг 1-р хороо, 220мянгат, 24-р байр 47 тоот хаягт байрлах, Регистерийн 5235987 дугаартай "Рэд лайн" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ийг түүнийг төлөөлж тус газрын менежер Ц.Аззаяа нар Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлийг үндэслэн, харилцан тохиролцож, энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь АТГ-ын "Б" байрны 2-р давхрын 55.51кв талбай бүхий мөрдөгч нарын өрөөний засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх. Захиалагч нь Гүйцэтгэгчид энэхүү гэрээний дагуу ажлын хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаа, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлно.

1.2. Гэрээний төлбөр тооцоотой холбоотой нэхэмжлэх болон санхүүгийн бусад баримтууд, гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн, хүлээн авсан акт нь энэхүү гэрээний хавсралт бөгөөд салшгүй хэсэг болно.

#### Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Захиалагч нь гүйцэтгэгчээс ажлыг гэрээгээр тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд доголдолгүй, бүрэн хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй

2.2 Гүйцэтгэгч талаас бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, танилцуулгыг авах эрхтэй.

2.3 Захиалагч нь ажлын явцтай танилцах, хяналт тавих, гэрээнд заасан үүргийн зохих ёсоор, шударгаар бодитоор хугацаанд нь биелүүлэхийг шаардах эрхтэй

2.4 Доголдолыг арилгуулахаар шаардлага тавьсан нөхцөлд тогтоосон хугацаанд ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол ажлын хөлсийг бууруулах, эсхүл захиалагч нь доголдолыг арилгуулах арга хэмжээ авч, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх

2.5 Засвар, үйлчилгээний талаархи гомдол саналыг гүйцэтгэгч талд гаргаж, шийдвэрлүүлнэ.

2.6 Чанарын шаардлага хангасан ажлыг тохирсон хугацаанд нь хүлээн авах, гэрээнд заасан хугацаанд зохих журмын дагуу гэрээний хөлсийг төлөх

2.7 Хуульд заасан бусад эдэлж үүрэг хүлээнэ

#### Гурав. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

3.1 Өөрийн үзүүлэх засварын үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, танилцуулгыг захиалагч талд урьдчилан танилцуулна.

3.2 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаанд захиалагч талаас шаардагдах эд материал, нэмэлт мэдээллийг авна.

3.3 Гэрээнд заасан ажлыг чанар, загварт өөрчлөлт орох бол энэ тухай захиалагчид мэдэгдэж, зөвшөөрөл авах

3.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ билелүүлэх, гэрээнд заасан хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй

3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх

3.6 Гэрээгээр тохиролцсон хугацаанд ажлыг чанарын өндөр түвшинд доголдолгүй хийж гүйцэтгэх

3.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### Дөрөв. Гэрээний төлбөр тооцоо, хугацаа

4.1. Захиалагч тал Гүйцэтгэгч талаас ирүүлсэн энэхүү гэрээгээр тохиролцсон гэрээний нийт хөлс болох 16,154,299 төгрөг /Арван зургаан сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун ерэн ес/-ийн урьдчилгаа хөлс болох нийт төлбөл зохих хөлсний 50 хувь болох 8,077,150 төгрөг /найман сая далан долоон мянга нэг зуун тавин төгрөг/-ийг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр, ажлыг гүйцэтгэлийг 80%-тай биелүүлснээр үлдэгдэл хөлсний 30% болох 4,846,290 төгрөг /дөрвөн сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун ер/-ийг, гэрээний үүрэг бүрэн хангагдсаны дараа үлдэгдэл 20% хөлс болох 3,230,860 төгрөг/гурван сая хоёр зуун гучин мянга найман зуун жар/-ийг талууд ажлыг актаар хүлээлцсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгчийн Хаан банкны 5011142482 дугаар дансанд шилжүүлнэ.

4.2. Энэхүү гэрээний 1.1-д заасан гүйцэтгэх ажлын урьдчилгаа хөлс гүйцэтгэгч талын дансанд орсноор захиалга баталгаажсанд тооцно.

4.3. Захиалагч нь гүйцэтгэгчид төлөх төлбөрөө 4.1-д заасан хугацаанаас хоцруулбал үйл ажиллагаа цуцлагдсанд тооцно.

4.4. Захиалагч тал засвар үйлчилгээнд өөрчлөлт оруулах бол бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авахаас 2 хоногийн өмнө мэдэгдэж хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

4.5. Захиалагч нь төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувийн алдангийг гүйцэтгэгчид төлнө.

4.6. Гүйцэтгэгч захиалагчийн энэхүү гэрээгээр тогтоосон хугацаанд засвар, үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгээгүй, хугацаа хоцроосон эсвэл чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнээр хийсний улмаас гэм хор учирсан тохиолдолд захиалагч талд төлбөрийг буцаан олгоно.

4.7. Энэхүү гэрээ нь 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байх ба гүйцэтгэгчээс захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн засвар, үйлчилгээг хийж, төлбөр бүрэн хийгдснээр дуусгавар болно.

#### Тав. Гэрээ цуцлах

5.1 Гэрээг цуцлах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

5.2 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцалж болно. Үүнд:

5.2.1 Талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй;

5.2.2 Гэрээний хугацаа дуусгавар болсон;

5.2.3 Талуудын аль нэг нь гэрээг цуцлах саналыг бичгээр илэрхийлсэн;

5.2.4 Давагдашгүй хүчин зүйл (Үер ус, байгалийн гамшиг, дайн, дайны байдал, өвчин тахал, гал түймэр, байгалийн аюул, үүрэг биелүүлэхэд нөлөөлсөн төрийн байгууллагын акт, эрх бүхий шүүх, арбитрын байгууллагын шийдвэр г.м) тохиолдож түүнийг арилгах хугацаа гэрээний үүргээ бүрэн биелүүлэхэд саад учруулж байгаа тохиолдолд;

#### Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас буюу гал, түймэр, газар хөдлөлт, салхи шуурга аянга цахилгаан, дайн байлдаан, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хоригоос шалтгаалан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд хариуцлага хүлээхгүй байж болно.

6.2. Мөн 6.1 дэх заалтаас үл хамааран цахилгааны гэмтэл, захиалагч, болон гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гал түймэр болон ус алдалт, хулгай, дээрэм зэрэг үйлдлийн улмаас үүссэн хохирлыг захиалагч тал бүрэн хариуцна.

#### Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан аливаа маргаантай асуудлыг гэрээнд оролцогч талууд харилцан ойлголцлын замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2. Энэ гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурж урьдчилгаа төлбөр төлөгдсөн цагаас эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний аль нэг хувьд засварлаж бичсэн бичилтийг хүчингүйд тооцно.


7.3. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж Захиалагч тал 2 эх хувь, гүйцэтгэгч тал 1 эх хувь хүлээлгэн өгнө. Гэрээний эх тус бүр хууль зүйн хувьд адил хүчин чадалтай байна.

7.4. Талуудын харилцан тохиролцсоноор бичгээр оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Захиалагчийг төлөөлж:

Авлигатай тэмцэх газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, ахлах комиссар

/Ш.Азбаяр/


Гэрээ хянасан:

Мөн газрын Тамгын хэлтсийн ажилтан, комиссар

/Б.Энхтайван/

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Рэд лайн ХХК-ний менежер

/Ц.Азжаяа/

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Сөүлийн гудамж- 41  
Утас: 70112477

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 220 мянгат 24-47  
Утас: 99072821, 11333390